



Бурхан бол Аугаа Гайхамшигтай Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: **Бурхан бол Аугаа Гайхамшигтай**

Attribute: God Is Awesome

Тодорхойлолт: Хүндлэл бишрэлийг хүртэх Нэгэн; Сүр жавхланта, Агуу сүртэй, Гайхан бахдам, шагшин магтмаар.

Эшлэл(үүд):

- **Гэтлэл 15:11** Аяа, ЭЗЭН, бурхдаас хэн нь Тан лугаа адил Ариун нь үлэмжийн, Алдар нь аймшигт, Үйлс нь гайхамшигтай вэ?
- **Иов 37:22** Умардаас алт мэт гэрэлтэх сүр жавхлан гарч ирж, Бурханы эргэн тойронд аймшиг төрөм цог жавхлан байдаг.
- **Дуулал 47:1-2** Хүмүүс ээ, бүгд алгаа таш. Уухайн дуугаар Бурханд хашхирагтун. Учир нь Хамгийн Дээд ЭЗЭН Аймшигтай бөгөөд Бүх дэлхийн аугаа Хаан юм.
- **Дуулал 66:1-5** Бүх газар дэлхий, Бурханд баяртайгаар хашхир! Түүний нэрийн сүр жавхланг дуул, Магтаалыг нь сүр жавхлантай болго! Бурханд “Таны үйлс хэчнээн сүрдмээр вэ! Таны хүч аугаа учраас Дайснууд тань Таны өмнө бялдуучилна. Бүх дэлхий Танд мөргөж, Таныг магтан дуулна Тэд Таны нэрийг магтан дуулна” гэж хэл. Села Ирээд, Бурханы үйлсийг үз, Хүний хөвгүүдэд үйлдсэн нь сүрдэм!

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дэд хууль 10:20-21

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) маань Эзэн Бурхан Таниас эмээн үйлчилж Танд өөрийгөө зориулах болтугай. Та

(Хүүхдийн нэр) маань хувьд цор ганц биширдэг Нэгэн байх болтугай. Эзэн Бурхан минь та түүний Бурхан Эзэн нь байж өгөөрэй. Эзээн, (Хүүхдийн нэр) -ийн сүнслэг нүдийг нээж өгөөч, тэгсэнээр тэр өөрийн нүдээр Таны түүний төлөө бүтээх гайхамшигт үйлсийг харах болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ маань Эзэн Бурхан Таниас эмээн үйлчилж Танд өөрийгөө зориулах болтугай. Та _____ маань хувьд цор ганц биширдэг Нэгэн байх болтугай. Эзэн Бурхан минь та түүний Бурхан Эзэн нь байж өгөөрэй. Эзэн, _____-ийн сүнслэг нүдийг нээж өгөөч, тэгсэнээр тэр өөрийн нүдээр Таны түүний төлөө бүтээх гайхамшигт үйлсийг харах болтугай. *Дэд хууль 10:20-21*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!